

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2022 – 01 сар | Дугаар 38

ГАРЧИГ

2–4 Бодлогын нийтлэл

5–7 Зохицуулалтын мэдээ

8–10 Байр суурь

11–12 Биологийн олон янз байдлын санхүүжилт

13 Финтек орчин дахь төлбөрийн шинэлэг шийдэл

14–18 Хөрөнгийн зах зээлийн системийн эрсдэлийн үнэлгээ

19–21 Санхүүгийн боловсрол

22–23 Компанийн засаглал

24–25 2021 оны өргөдөл гомдлын тайлан

26–27 Олон улсын зах зээлийн мэдээ

ЦУВРАЛ ХИЧЭЭЛ

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №7

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд



САНХҮҮГИЙН ЭРСДЭЛЭЭС ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

Санхүүгийн эрсдэл гэдэг нь: хөрөнгө оруулж, хуримтлуулсан хөрөнгөө алдах болон алдаж болохуйц нөхцөл байдалд орохыг хэлнэ.

Эрсдэл үүсгэж болох хүчин зүйлс:



Мэдээллийн хомс байдал

- Хангалттай мэдээлэл авсан эсэхээ нягтлах
- Харилцагч байгууллагаасаа нэмэлт мэдээлэл шаардах
- Харилцагч байгууллагын талаар судлах



Хүлээгдээгүй үр дүн

- Эрсдэл, өгөөжөө тооцож, түүний алдах магадлалыг таамаглах
- Эдийн засгийн хүчин зүйлсийг тооцох



Хэрэгцээндээ тохироогүй бүтээгдэхүүн сонгох

- Санхүүгийн зорилго, хэрэглээгээ нарийвчлан тодорхойлох



Залилан болон хулгайд өртөх

- Нууц үгээ тогтмол шинэчлэх
- Даатгуулах

“Эрх ашгаа хамгаалах”

талаар нэмэлт мэдээллийг дараах эх сурвалжаас унших боломжтой



Санхүүгийн эрсдэлээс хамгаалах гол арга нь **Та өөрийнхөө эрх ашгаа хамгаалахад анхаарах** юм шүү...



<http://www.frc.mn/a/3752>



<https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/31.pdf>



<http://www.frc.mn/resource/frc/File/2021/03/24/InbaSlyz3icimsqa/qarin%20aviaga.pdf>



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

Үргэлжлэл 20-р нүүр



**ТАНЫ
САНХҮҮГИЙН
МЭДЛЭГТ**

САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ

Албан ба албан бус санхүүгийн салбарт хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрвөх чадварыг удирдах, хувь хүн болон байгууллагаас татан төвлөрүүлсэн хадгаламжийг байгууллага болон хувь хүмүүст зээлийн хэлбэрээр хуваарилан байршуулдаг.



FINANCIAL INTERMEDIATION

The process by which the formal and informal financial sectors manage liquidity the economy, reallocating liquid resources by mobilizing savings from institutions and individuals.

Эх сурвалж:

Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮДИЙН 18.9 ХУВЬ НЬ ӨРХИЙН БОЛОН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ



Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд зааснаар хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-ны нийт гишүүдийн 10 хүртэл хувь нь хуулийн этгээд байх боломжтой бөгөөд өрхийн бизнес эрхлэгч буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид цөөнгүй хувийг эзлэх нь дэлхий нийтэд түгээмэл байна. Учир нь орлого багатай, барьцаа хөрөнгийн дутагдалтай, санхүүгийн үйлчилгээ авах боломж хомс санхүүгийн хэрэглэгчид бичил санхүүгийн байгууллагаар үйлчлүүлж, санхүүгийн хэрэгцээгээ хангадаг.

Дэлхийн эдийн засагт, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд жижиг, дунд бизнес чухал үүрэгтэй бөгөөд дэлхийн нийт бизнесийн 90 орчим хувь, ажлын байрны 50 гаруй хувийг бүрдүүлдэг байна.¹ Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (БЖДҮ)-ийг дэмжих замаар эдийн засгийн идэвхгүй хүн амыг идэвхжүүлж, албан бус салбарт хөдөлмөр эрхэлдэг иргэдийг албан салбарт шилжүүлэх, санхүүгийн хүртээмжийг тогтвортойгоор тэлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлж ядуурлыг

бууруулах, цаашлаад ажиллах хүчний оролцооны түвшинг дээшлүүлэх боломж бүрддэг учраас тэдэнд чиглэсэн санхүүжилтийн асуудал чухалд тавигддаг.

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн гишүүнчлэлд 2009 онд элссэнээс хойш тасралтгүй хамтран ажиллаж байна. AFI нь БЖДҮ эрхлэгчдэд учирдаг гарааны барьцаа хөрөнгийн дутагдалтай байдал, санхүүгийн боловсрол болон технологийн хэрэглээний түвшин доогуур зэрэг бэрхшээл болон БЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүд, залуусын санхүүжилтийн асуудлыг дэмжсэн бодлого тодорхойлох шаардлага улс орон бүрт тулгардаг учраас харилцан туршлага судлах зорилго бүхий “БЖДҮ-ийн санхүүжилт” ажлын хэсгийг үүсгэн байгуулсан. Энэ хүрээнд “БЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн бодлогын загвар”²-ыг боловсруулж БЖДҮ эрхлэгчдийг санхүүжүүлэх бодлого боловсруулахад ашиглах 6 тулгуур үзүүлэлтийг санал

¹<https://www.montsame.mn/mn/read/278528>

²<https://www.afi-global.org/publications/policy-model-for-msme-finance/>

болгосон. Үзүүлэлт бүр нь гишүүн улсуудын нөхцөл байдалд тохируулан хэрэглэх боломжтой ерөнхий зарчмуудыг агуулсан байдаг. Үүнд:


- 1. Зохицуулалтын орчин:** БЖДҮ эрхлэгчдийн санхүүжилттэй холбоотой зохицуулалтууд нь үр ашигтай, зохистой, санхүүжилтийн боломжуудыг нээх, санхүүжилт авах нөхцөлийг хөнгөвчлөх ёстой бөгөөд БЖДҮ эрхлэгчдийг оновчтой тодорхойлох.
- 2. БЖДҮ-ийн санхүүжилтийн бодлого:** БЖДҮ-г санхүүжүүлэх үр ашигтай, зохимжтой бодлогын хэмжүүр үзүүлэлтүүдийг хөгжүүлж хэрэгжүүлэх, санхүүжилтийг идэвхтэй хэрэгжүүлэх стратеги боловсруулах, зээл авахад саад болдог зохицуулалтыг өөрчилж санхүүгийн боломжийг нэмэгдүүлэх, зээл олгох процессод анхаарах, зорилтот бүлгийн зээлдэгчдийн хэрэгцээнд нийцсэн төлбөрийн нөхцөлийг агуулсан бодлого, төлбөрийн системийг бий болгох, дижитал төлбөрийн бодлого бий болгох.
- 3. Зээлийн дэд бүтэц:** Зээлийн мэдээллийн үзүүлэлтүүдийг тодорхой болгох, зээлийн мэдээллийн боломжийг нэмэх, зээлийн батлан даалтын хуулийн болон зохицуулалтын орчныг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд экспортын баталгааны схемийг үүсгэх.
- 4. Санхүүжилтийн бусад сувгууд:** Лизингийн бодлого, хамтын санхүүжилтийн бодлого P2P /Peer to peer/ зээл, дижитал санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх бодлого хөгжүүлэх.
- 5. Зах зээлийн үр ашигтай байдал:** БЖДҮ-г хөгжүүлэх экосистемийг бий болгох хамтын ажиллагааны бүтцийг дэмжих бодлого хэрэгжүүлэх, байгууллагын чадавхыг дэмжих, технологид суурилсан хяналт шалгалт болон зохицуулалтын хэрэгслийг нэвтрүүлэх, БЖДҮ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах.



ХЗХ-НЫ ГИШҮҮН ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ:

Зах зээлд тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа нийт ХЗХ-дын дунд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар судалгаа явуулахад нийт гишүүдийн 18.9 хувь нь өрхийн болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч байна. Эдгээрийн 39.5 хувь нь Улаанбаатар хотод, 60.5 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ХЗХ-дын “гишүүн өрх”-ийн болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчийн үйл ажиллагааны чиглэл нь Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 319, А/160 дугаар тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ангиллын тодорхойлолт”-ын дагуу дараах ангилалд хамаарч байна.



Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ны гишүүдийн хувьд мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногооны аж ахуйг түлхүү эрхэлдэг бөгөөд сүү, сүүн бүтээгдэхүүн, цагаан идээ боловсруулж, худалдаалах өрхийн бизнесийг эрхэлдэг бол Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ны гишүүдийн хувьд хүнс, бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдааг түлхүү эрхэлж байна.

ХЗХ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхээс гадна хуулиар хориглоогүй, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн хэд хэдэн төрлийн санхүүгийн үйлчилгээг эрхлэх боломжтой бөгөөд эдгээрт бичил бизнес, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа хамаарна. Энэхүү үйлчилгээ нь

өрхийн болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хямд эх үүсвэрээр хангах замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах, түүнчлэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх чухал арга замын нэг болдгоороо давуу талтай.

ДЭЛХИЙН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ЗӨВЛӨЛ (WOCU)-ӨӨС ТАНИЛЦУУЛЖ БҮЙ ХЗХ-НЫ ЗАХ ЗЭЭЛД ОЛОН УЛСАД ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСЛҮҮД:

Санхүүгийн хүртээмжийн технологи, инноваци (CD, TIFI) төсөл: Тус хөтөлбөр нь Гватемал, Сенегал, Буркина фасо, Кени улсуудад 2018–2023 онд АНУ–ын олон улсын хөгжлийн агентлаг (USAID)–ийн санхүүжилтээр хэрэгжиж байна. ХЗХ нь хадгаламж, зээл, бичил даатгал зэрэг амьжиргааг нэмэгдүүлэх санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хэдий ч хөгжиж буй орнуудад БЖДҮ–ийн зээлийн хангагдаагүй эрэлт ихээхэн байх бөгөөд энэ нь нэг талаас ХЗХ–дод санхүүжилтийг хүргэх чадавх, хэрэгсэл дутмаг байгаатай холбоотой гэж үзсэний үндсэн дээр энэхүү төлсийг амжилттай хэрэгжүүлж байна.

Жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын (GLI) төсөл: Тус төсөл нь 2020–2022 онд хэрэгжиж байгаа бөгөөд шинэлэг сувгуудаар дамжуулан эмэгтэйчүүдэд үзүүлэх санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх, ажиллах хүчийг хөгжүүлэх боломж, таатай орчныг бэхжүүлэх замаар жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой юм. ХЗХ–д эмэгтэй бизнес эрхлэгчдэд илүү хүртээмжтэй үйлчлэх үүднээс WOCU–ын Жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын хурдасгуур (GLI Accelerator Kit)–ыг ашиглан хөгжүүлэх, байршуулах, өргөтгөх гэсэн 3 үе шаттайгаар тохиромжит арга хэрэгслүүдийг бий болгохоор ажиллаж байна.

Украин улсын хөдөө аж ахуйн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх төсөл: Тус төсөл нь USAID–ийн санхүүжүүлж буй Украин Улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд зориулсан зээлийг санхүүжүүлэх төсөл бөгөөд 2016 онд эхэлсэн төслийг 2020–2023 он хүртэл сунгасан байна. Украин Улсын хувьд жижиг, дунд фермүүд, хувиараа бизнес эрхлэгчид боломжит зээлд хамрагдаж чаддаггүй бөгөөд цорын ганц эх үүсвэр нь ХЗХ байдаг байна. Иймд уг төслийн зорилго нь Украины ХЗХ–ны зах зээлийг бэхжүүлж, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангуулж, урт хугацааны өсөлтийн суурийг бий болгож, улмаар хөдөө аж ахуйн зээлийн хүртээмжийг өргөжүүлэх явдал юм.

Венесуэлийн цагаачид болон бага орлоготой нутгийн иргэдэд санхүүгийн үйлчилгээ хүргэх, хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэлтийг дэмжих төсөл: Уг төсөл нь гарааны болон одоо байгаа бизнес эрхлэгчдэд туслах, хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд хэрэгжиж байна. WOCU–аас ХЗХ–д, төрийн бус байгууллага, хувийн хэвслүүдтэй хамтран Венесуэлийн эмзэг бүлгийн иргэд болон орон нутгийн хүн амд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхээр ажиллаж, төслийн үр дүнд 100,000 гаруй иргэн санхүүгийн шинэ үйлчилгээ авах боломжтой болно гэсэн хүлээлттэй байна.

Эх сурвалж: https://www.woccu.org/international_projects/current_projects

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 64 ХЗХ хадгаламж, зээлээс бусад зөвшөөрлийн үндсэн дээр нэмэлт үйл ажиллагааг эрхэлж байгаа бөгөөд одоогоор Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хэрэгжүүлж буй “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”, Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт–Малын эрүүл мэнд” төсөл, Дэлхийн

байгаль хамгаалах сангийн “Ирвэстэй нутгийн ирээдүй” зэрэг төсөл, хөтөлбөрүүд ХЗХ–ны зах зээлд хэрэгжиж байна.³ Эдгээр төслүүдийн үндсэн зорилго нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, бэлчээрийн тогтвортой менежментээр дамжуулан тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

³ <http://www.frc.mn/resource/frc/Document/2021/11/23>

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ХАМТАРЧ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР САНАЛ СОЛИЛЦЛОО




Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нэгдсэн холбоо хамтран төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцлоо. Уулзалтад Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Н.Энхтуяа, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Эрдэнэсийн сангийн захирал П.Эрдэнэтуяа, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Г.Мөнхцэцэг болон албаны бусад хүмүүс оролцлоо.

Уулзалтын үеэр талууд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо. Мөн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хувийн хэвшлийнхэн үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлэх чиглэлд хамтран ажиллах саналыг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэхээр болов.

Санхүүгийн зохицуулах хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс олгож эхэлсэн бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 40 хуулийн этгээд, 436 иргэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН АНХААРАЛД

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-д заасны дагуу хуралдуулж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8-д заасан үүргийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал болон холбогдох шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхдээ дараах хугацааг анхаарч ажиллана уу.




Хэрэв тогтоосон хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг бүрэн ирүүлээгүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос тухайн компанитай холбоотой аливаа тодорхойлолтыг гаргаж өгөх боломжгүй мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцохгүй болохыг анхааруулж байна.

ГАДААДАД СУУГАА МОНГОЛЧУУДАД ХӨРӨНГИЙН ЗАХ



ЗЭЭЛД ОРОЛЦОХ ҮҮД НЭЭГДЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын орчинг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэх, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд мэргэжлийн холбоод, дэд бүтцийн байгууллагуудтай байнга хамтран ажилладаг. Хамтын ажиллагааны хүрээнд өнөөдөр гадаадад ажиллаж, амьдарч буй монголчуудад хөрөнгийн зах зээлд хялбар, шуурхай байдлаар оролцох бололцоог бүрдүүлэх, зах зээлд цахим мөнгөний хэрэглээг нэмэгдүүлж үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын түвшинг сайжруулах цаашлаад хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн ажлыг эхлүүлж байна. Тодруулбал, “Хай пэймэнт солюшнс” ХХК, “Стоклаб секьюритиз УЦК” ХХК хамтран HiPay аппликейшн ашиглаж гадаадад ажиллаж, амьдарч буй монголчуудад онлайн цахим мөнгөний болон үнэт цаасны данс нээх, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон бусад ХК-аас ногдол ашгаа авах, цахим мөнгө ашиглаж хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах ёслол боллоо.



Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва, “Хай пэймэнт солюшнс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Наранбат, “Стоклаб секьюритиз” УЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Ё.Амарбат болон албаны бусад хүмүүс оролцсон юм. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар баталсан “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо “Мобифинанс ББСБ” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах компанийн бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, холбогдох зөвшөөрлийг өгсөн. Ингэснээр Монпэй аппликейшн / Monpay/ ашиглах замаар компанийн бондыг анхдагч зах зээлд санал болгон худалдаж, шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж, Үндэсний төлбөрийн системийн

тухай хууль 2017 онд батлагдсанаас хойш анх удаа цахим мөнгөөр дамжуулж үнэт цаас худалдан авсан.

Харин энэ удаад гадаадад байгаа монголчууддаа дотоодын хөрөнгийн зах зээлд хялбар, шуурхай байдлаар оролцох бололцоог бүрдүүлж, зах зээлд цахим мөнгөний хэрэглээг нэмэгдүүлж үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын түвшинг сайжруулахаар ажиллаж байгаад талархалтай байна. Цаашид ч Санхүүгийн зохицуулах хороо шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэвшилтэд технологийг дотоодын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр хувийн хэвшлээс хэрэгжүүлж буй санал, санаачилгыг бодлого, зохицуулалтаар дэмжиж, хамтран ажиллана” гэдгийг онцоллоо.

Санхүүгийн зохицуулах хороо Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгүүдэд туссан хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн бүтээлч санал, санаачилгуудыг байнга дэмжиж ажилладаг бөгөөд энэ удаад технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд шинээр нэвтрүүлж буй үйлчилгээтэй холбоотой хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хууль, журам, дүрмийн хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах юм.

ХАМТАРЧ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР САНАЛ СОЛИЛЦЛОО



Санхүүгийн зохицуулах хороо, Соёлын яам, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нэгдсэн холбоо хамтран төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үйл ажиллагаанд салбарын оролцогчдын тэгш оролцоог хангах, соёлын өвийг хамгаалах чиглэлд хамтран ажиллахаар санал солилцлоо. Уулзалтад Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Н.Энхтуяа, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нэгдсэн холбооны дэд тэргүүн О.Мөнгөнцоож болон холбогдох албаны бусад хүмүүс оролцсон юм.

Энэ үеэр гурван тал хамтын ажиллагааг дэмжиж ажиллахын зэрэгцээ мэдээ мэдээлэл солилцох, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, соёлын үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх цаашилбал салбарын мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллахаар боллоо.

ФИНТЕК ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарт финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нэр бүхий 29 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ болон Монголын финтекийн холбоотой хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр боллоо.

Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газраас зохион



байгуулсан энэхүү уулзалт, хэлэлцүүлгийн үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж буй финтек зээлийн үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлтийн байдал, зээлийн мэдээллийн санд нийлүүлж буй мэдээллийн талаар танилцууллаа. Мөн финтек зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, Санхүүгийн зохицуулах хороо ноос боловсруулсан ББСБ-уудын эрхлэх зээлийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох журмын төслийн талаар мэдээлэл өгөхийн зэрэгцээ харилцан мэдээлэл солилцож, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Цаашилбал финтект суурилсан үйл ажиллагааны онцлогтой нийцүүлж үйлчлүүлэгчдийн эрх ашиг, ББСБ-ын үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлээс хамгаалах чиглэлээр зохих дүрэм, журам, заавар, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны баримт бичгүүдэд холбогдох өөрчлөлтүүдийг хийн баталж, мөрдүүлэн ажиллах энэ талаарх тайлан мэдээг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор мөн уулзалтаар хэлэлцсэн асуудлын талаар санал хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хамтран ажиллахаар боллоо.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

Коронавируст халдвар /ковид-19/-т цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэлийн



хугацаа 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгагдсантай холбогдуулан ББСБ-уудын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын үйлчлэлийн хугацаа мөн дээрх хуулийн үйлчлэлийн дагуу сунгагдсан.

Харин ББСБ-ууд 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн активыг ангилахдаа Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 998 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилахыг анхаарна уу.



БАЙР СУУРЬ

БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛЭЭР ДАМЖУУЛАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ТЭЛЭХ БОЛОМЖ БИЙ

Санхүүгийн зохицуулах хорооны хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуултай ярилцлаа.

Энэ удаа ярилцлагаа хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж, арга замын талаар чиглүүлье гэж бодож байна?

Юуны түрүүнд 2021 оны 4 дүгээр улирлын байдлаарх зах зээлийн статистик, тоо баримтыг товч дурдъя. Нийт 209 хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-нд 75,400 гишүүн бүртгэлтэй байгаагаас 32,534 нь зээлдэгч, 33,600 нь хадгаламж эзэмшигч гишүүн байгаа бөгөөд хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар өсөж 291.2 тэрбум төгрөгт, нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өсөж 213.4 тэрбум төгрөгт, нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар өсөж 203.6 тэрбум төгрөгт тус тус хүрсэн. Хэдийгээр цар тахлын нөлөөгөөр 2020 оны дундуур зах зээлийн өсөлт саарч байсан ч 2021 оны дундаас эхлээд эргэн хэвийн үеийн дундаж өсөлтийн түвшинд ирж байна.

Бичил санхүүгийн байгууллагад тулгардаг гол асуудлын нэг бол яах аргагүй санхүүжилт байдаг бөгөөд хямд эх үүсвэрээр олон хэрэглэгчийн санхүүгийн хэрэгцээг хангаснаар эдийн засагт үзүүлэх бодит нөлөөллийг нэмэгдүүлэх боломж бүрддэг. 2021 онд Хоршооны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2021 оны 40 дүгээр тогтоолоор хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээг тодорхойлсон бөгөөд тогтоолд сум хөгжүүлэх санг хоршоог дэмжих сан болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хоршоонд олгох санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгуулж байх, 2022 оныг хоршооны хөгжлийг дэмжих жил болгон зарлаж хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх зэрэг чухал арга

хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тусгасан. Тэгэхээр эдгээр зорилтуудаас улс орны түвшинд ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орон нутгийн хөгжилд шууд хувь нэмэр оруулах боломжтой хоршооны хөгжлийг хурдасгах нь бодлогын түвшинд зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэдгийг харж болно. ХЗХ-ны гишүүдийн хувьд өрхийн бизнес эрхлэгч буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (БЖДҮ) эрхлэгч багагүй хувийг эзлэх нь дэлхий нийтэд түгээмэл хандлага. ХЗХ-ны санхүүжилтийн асуудлыг гишүүн өрхийн болон БЖДҮ эрхлэгчид, мөн хувь хүн гишүүний санхүүгийн хэрэгцээг хангах замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх 2 чиглэл рүү салгаж болно. Бид 2021 онд ХЗХ-ны гишүүн өрхийн болон БЖДҮ эрхлэгчдийн судалгааг шинэчилсэн байгаа.

ХЗХ-ны гишүүдийн хэдэн хувь нь өрхийн үйлдвэрлэл болон БЖДҮ эрхлэгч байдаг вэ? Судалгааны үр дүнгийн талаар тодруулаад дэлгэрэнгүй ярьж өгөхгүй юу?

БЖДҮ эрхлэгчид нь улсын эдийн засгийн өсөлтийн хөтөлгөч болохын зэрэгцээ ажлын байр бий болгох, санхүүгийн хүртээмжийг тогтвортойгоор тэлэх, бичил хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид нь ялангуяа өрхийн түвшний ядуурлыг бууруулахад ач холбогдолтой гэж үздэг. Дэлхий дээрх нийт бизнесийн 90 орчим хувь, ажлын байрны 50 гаруй хувийг БЖДҮ бүрдүүлдэг гэсэн тооцоо ч үүнийг батална. ХЗХ-ны зах зээлд, ХЗХ-ны гишүүдийн хувьд байдал ямар байгааг тодорхойлохоор 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх дүн мэдээнд судалгаа хийхэд ХЗХ-дын нийт гишүүдийн 18.9 хувь нь өрхийн болон БЖДҮ эрхлэгч бөгөөд дийлэнх буюу 60.5 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байна. Үйл ажиллагааны чиглэлийг нь ангилж үзэхэд хамгийн их

хувийг хөдөө, аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлийн үйл ажиллагаа хамаарч байна. Энэхүү үйл ажиллагааны чиглэл нь хот болон орон нутгаасаа хамаараад харьцангуй байдалтай. Жишээлбэл, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ны гишүүдийн хувьд мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногооны аж ахуй, сүү, цагаан идээ боловсруулж, худалдаалах өрхийн үйлдвэрлэлийг эрхэлдэг бол Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ны гишүүдийн хувьд хүнс, бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа тэргүүн байрыг эзэлж байгаа нь харагдсан.

Тэгвэл эдгээр өрхийн үйлдвэрлэл болон БЖДҮ эрхлэгчдийг санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд ямар зарчмыг баримталж, ямар арга хэрэгслийг ашиглах нь зөв бэ?

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI) гэж дэлхийн 90 гаруй улс орны санхүүгийн зохицуулагч байгууллагыг гишүүнээрээ элсүүлсэн, санхүүгийн үйлчилгээг хүн амд жигд хүргэх буюу хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримталдаг олон улсын байгууллага бий. Санхүүгийн зохицуулах хороо нь мөн AFI-ийн гишүүн. AFI-аас “БЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн бодлогын загвар”-ыг гаргаж, БЖДҮ эрхлэгчдийг санхүүжүүлэх бодлого боловсруулахад ашиглах 6 тулгуур үзүүлэлтийг санал болгосон байдаг. Аль ч улсын нөхцөлд тохируулан ашиглах боломжтой ерөнхий зарчмуудыг тулгуур үзүүлэлт болгосон учраас манай нөхцөлд ч загвар болгох боломжтой юм. Эдгээр зарчмуудаас дурдвал БЖДҮ нарын энгийн санхүүгийн үйлчилгээ, зээл авахад учирдаг бэрхшээлийг багасгах, санхүүжилт авах нөхцөлийг хөнгөвчлөх, зээл олгох процессод анхаарах, дижитал төлбөрийн систем дэмжих бодлоготой байх, зорилтот бүлгийн зээлдэгчдийн хэрэгцээнд нийцсэн төлбөрийн нөхцөлийг агуулсан бодлоготой байх, санхүүжилтийн өөр суваг хувилбаруудыг үүсгэх, ногоон санхүүг дэмжих зэрэг хоорондоо салшгүй холбоотой асуудлуудыг хамруулсан бөгөөд бичил санхүүгийн байгууллага, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын харилцан уялдаа бүхий тасралтгүй хамтын ажиллагаа чухал нь харагддаг.

Дэвшүүлсэн зарчмууд нь чухал юм байна. Зээлийн дэд бүтэц болон санхүүжилтийн бусад сувгууд гэх ойлголтууд сонирхолтой санагдаж байна. Зээлийн мэдээллийн боломжийг нэмэх талаар, зээлийн батлан даалтыг тодотгож яриач?

Тэгэхээр зээлийн мэдээллийн санд БЖДҮ эрхлэгчдийн мэдээллийг нэгтгэхийн гол ач холбогдол нь зээлийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийн бааз бүрддэг бөгөөд мэдээллийн санг хөгжүүлэхдээ биг дата, хиймэл оюун ухаан зэрэг технологийн дэвшлийг ашигласнаар мэдээллийн аюулгүй, үнэн зөв байдал хангагдаж, зээлийн үнэлгээг бодитоор хийхэд илүү түлхэц үзүүлнэ гэдгийг онцолмоор байна.

Зээлийн батлан даалтын сангийн хувьд албан ёсны хуулийн этгээд болох БЖДҮ-ийн барьцаа хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор батлан даалт гаргадаг. Санхүүгийн зохицуулах хороо нь Зээлийн батлан даалтын сантай хамтын ажиллагааны хүрээнд ХЗХ-ны гишүүдийн зээлийн батлан даалтын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, цаашлаад батлан даалттай зээлийг нэмэгдүүлэх чиглэлээр тухайлан ХЗХ-ны зах зээлийн онцлогт нийцсэн бүтээгдэхүүнийг бий болгох чиглэлээр анхаарал хандуулж хамтран ажиллагааг эхлүүлээд байна. Мөн ХЗХ-ны гишүүн хувь хүний зээлд батлан даалт гаргах боломжтой эсэх асуудал ч хөндөгдөх нь зайлшгүй.

Санхүүжилтийн бусад суваг гэдэгт хамтын санхүүжилт буюу краудфандинг, P2P буюу дундын зуучлалгүй зээлийн хэлбэр, дижитал санхүүгийн хэрэгсэл, платформ үүсгэх асуудал хөндөгддөг. Хамтын санхүүжилтийг дэлхий дахинд хувь хүн, гарааны бизнес эрхлэгчдээс том хэмжээний бизнес эрхлэгчид гээд олон салбарт ашиглаж амжилт олж байсан байдаг. Уламжлалт хөрөнгө оруулалттай харьцуулахад олон давуу тал бий боловч нөгөө талдаа тодорхой эрсдэлүүд байгаа гэдгийг мартаж болохгүй.

Зорилтот бүлэг, ногоон санхүүжилт зэрэг асуудлыг тодруулбал?

БЖДҮ-ийг санхүүжүүлэх асуудлын хувьд эмэгтэйчүүд, залуучууд, тодорхой орон нутгийн нэгж рүү чиглэсэн гэх мэтээр зорилтот бүлэг тус бүрт тохирсон бүтээгдэхүүнийг бий болгох нь илүү үр дүнтэй байдаг. Санхүүгийн зохицуулах хороо нь жендерийн мэдрэмжтэй санхүүгийн

асуудалд анхаарал хандуулж байгаа бөгөөд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Монгол Улсад хэрэгжүүлж буй "Төв азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хөтөлбөр" төслийн удирдах зөвлөлд төлөөлөл ажиллаж байна. Энэ хүрээнд хүйсээр ангилсан мэдээллийн статистикийг боловсронгуй болгох, эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, тэдэнд чиглэсэн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөөд эхлүүлээд явж байна.

Дэлхий нийтээр тогтвортой санхүүжилтийн бодлогыг баримталж байгаа энэ цаг үед ХЗХ-ны бүтээгдэхүүн үйлчилгээ ч мөн ногоон санхүүжилт рүү чиглэх ёстой нь дамжиггүй. Санхүүгийн зохицуулах хорооноос Азийн хөгжлийн банктэй хамтран ногоон санхүүжилтийг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд бичил санхүүгийн салбар, ХЗХ зах зээл дэх ногоон санхүүгийн хүртээмжтэй байдлын судалгаа, үнэлгээг хийж, зохицуулалтын баримт бичигт оруулах өөрчлөлтийн саналыг бэлтгэж, ногоон санхүүгийн талаарх олон улсын

туршлагыг таниулах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад хамтран ажиллах болно.

БЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд юуг анхаарах вэ?

Энгийн санхүүгийн үйлчилгээг авахад БЖДҮ эрхлэгчдэд учирдаг бэрхшээлүүд, тухайлбал, бизнес эхлүүлэх хөрөнгийн дутагдал, барьцаа хөрөнгөгүй байх, санхүүгийн боловсрол болон технологийн хэрэглээний дутуу байдал зэрэг саадыг арилгах, БЖДҮ экосистемийг хөгжүүлэхэд төр болон хувийн хэвшлийн бүхий л талын хамтын ажиллагаа чухал байна. Санхүүгийн асуудал хариуцсан, БЖДҮ-тэй холбоотой асуудал хариуцсан төрийн байгууллагууд, мөн холбогдох дэд бүтцийн байгууллагууд БЖДҮ-г хөгжүүлэх нэг зорилгын төлөө хамтран ажилласнаар санхүүгийн хүртээмжийг тэлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зэргээр эдийн засагт бодит хувь нэмэр оруулахуйц ач холбогдол бүрэн утгаараа бий болно.

Ярилцсанд баярлалаа.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН САНХҮҮЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт Н.Нарантуяа

Сайн байна уу, уншигч Та бүхэндээ шинэ оны эхний дугаараар биологийн олон янз байдлын санхүүжилтийн талаар хүргэхээр нийтлэл бэлтгэлээ.

Биологийн олон янз байдал гэдэг нь хүрээлэн буй орчныг бүрдүүлж буй ургамал, амьтан, экосистем, генетикийн олон янз байдал, төрөл зүйлийг агуулдаг байгалийн цогц бүрдлийг хэлнэ. Биологийн олон янз байдал алдагдаж, улмаар санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаатай холбоотой тус төрлийн санхүүжилтийг Засгийн газар, санхүүгийн байгууллагууд шинээр гаргахаар анхаарах болсон.

Дэлхий даяар жил бүр биологийн олон янз байдлын алдагдлыг нөхөхөд 143.0 тэрбум ам.долларын санхүүжилтийг зарцуулдаг. Уг санхүүжилтийн 78.0 хувийг хөгжингүй улс орнууд, 22.0 хувийг хөгжиж буй орнууд гаргасан байна. Харин уг санхүүжилтийг хөрөнгө оруулсан байдлаар ангилбал 59.0 хувь нь хөгжингүй, 41.0 хувь нь хөгжиж буй болон өсөж буй зах зээлтэй орнуудад хөрөнгө оруулалт хийгджээ.

Санхүүжилтийн зориулалтаар ангилвал дараах 8 хэсэгт багтана:

Д/д	САНХҮҮЖИЛТИЙН ЗОРИУЛАЛТ	ХЭМЖЭЭ /ТЭРБУМ АМ.ДОЛЛАР/	ХУВЬ (%)
1	Засгийн газрын төсөв	75 – 78	52.4% – 55%
2	Байгалийн дэд бүтэц	27	19%
3	Тусламж	4 – 10	2.8% – 7%
4	Биологийн олон янз байдлын тэнцвэр	6 – 9	4.2% – 6.3%
5	Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ	6 – 8	4.2% – 5.6%
6	Ногоон санхүүгийн бүтээгдэхүүн	4 – 6	2.8% – 4.2%
7	Филантроп	2 – 4	1.4% – 2.8%
8	Байгаль орчинд суурилсан шийдэл	1	0.7%

Эх сурвалж: *The little book of investing in nature, Global Canopy, 2012*

https://www.biofin.org/sites/default/files/content/knowledge_products/LBIN_2020_RGB_ENG.pdf

Биологийн олон янз байдлын санхүүжилтийг буцалтгүй тусламж, өрийн хэрэгсэл, төсөв зэргээс санхүүжүүлдэг ба дараах байдалтай байна. Тухайлбал:

- ◆ **Буцалтгүй тусламж:** Германы уур амьсгалын өөрчлөлтийн санаачилгаас 2008 оноос хойш уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын төслүүдэд санхүүжүүлж байна.
- ◆ **Өрийн хэрэгсэл/хувьцаа:** Ногоон бондын цар хүрээ тэлж байна.
- ◆ **Улсын төсөв:** Шри Ланка улсын хувьд фермерүүдийн эрүүл мэнд, байгаль орчны чанарыг сайжруулахын тулд химийн бордоог шинэчлэх хөтөлбөр гаргаж, санхүүжүүлсэн.
- ◆ **Зах зээл:** Nestlé компаниас усны чанарыг хадгалах экосистемийн үйлчилгээг Францын фермерүүдэд үзүүлсэн.
- ◆ **Зохицуулалт:** Байгаль орчны гэмт хэргүүдээс сэргийлэхэд чиглэсэн.
- ◆ **Эрсдэлийн удирдлага:** Ногоон хөрөнгө оруулалтын баталгаа нь Дэлхийн банкны Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлагаас гардаг.

Харин биологийн олон янз байдлын алдагдлыг бүрэн нөхөж, хамгаалахад 824.0 тэрбум ам.доллар шаардлагатай ба тус зөрүүг нөхөх дараах хэд хэдэн аргуудыг асуудлыг шийдвэрлэх байдлаар хэрэглэж болно.

Үүний тулд дараах асуултын хариултыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн:



Санхүүгийн зохицуулагч байгууллагын хувьд биологийн олон янз байдлыг хамгаалахад санхүүгийн байгууллагуудыг одоогийн хөрөнгө оруулалтдаа дахин үнэлгээ хийхийг шаардах ямар алхам байж болох вэ?



Зохицуулагч байгууллага санхүүгийн салбарт биологийн олон янз байдлыг таниулж, түүний эрсдэлийг тооцож, тайлагнах аргагүйгээр хангаж чадах эсэх



Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагад биологийн олон янз байдлын ямар асуудлуудыг тусгах вэ?



Дээрх асуултуудын хариултыг биологийн олон янз байдлын мэргэжилтнүүд, орон нутгийн төлөөлөгчид, зохицуулагч, бодлого тодорхойлогч болон санхүүгийн байгууллагынхан гээд бүх талуудыг оролцуулан шийдвэрлэх нь зохимжтой.



ФИНТЕК БА РЕГТЕК

ФИНТЕКИЙН ОРЧИН ДАХЬ ТӨЛБӨРИЙН ШИНЭЛЭГ ШИЙДЭЛ

Санхүүгийн технологийн салбар хурдацтай хөгжиж байна. Зайнаас төлбөр хийх, одоо худалдаж ав, дараа нь төл (BNPL), криптовалют зэрэг боломжуудыг ашиглан хэрэглэгчид ухаалаг утсаараа төлбөр хийхийг илүүд үздэг болсон.

УХААЛАГ ГАР УТАСНЫ ЗАЙНААС ТӨЛБӨР ТӨЛӨЛТ



Ойролцоох сүлжээ (NFC) бүхий борлуулалтын цэгийн системийг ашиглан зайн төлбөр тооцоог Apple Pay болон Google Pay зэрэг томоохон компаниуд анх дэлгэрүүлсэн. Ухаалаг утсанд суурилсан NFC нь банкны карттай адил функцтэй бөгөөд хэрэглэгч болон худалдаачдын зүгээс үзвэл бараг адилхан гэж хэлж болно. Гэсэн хэдий ч ухаалаг утсанд суурилсан NFC систем бүрэн ашиглагдаагүй байгаа нь өндөр хүлээлт үүсгээд

байна.

Хэрэглэгчид аль болох цөөн алхмаар контактгүй, дижитал төлбөрийн аргыг илүүд үзэх болсон. Канадад төвтэй Жоббер зэрэг зарим финтекийн бизнесүүд урамшуулал хүртэл санал болгодог. Компанийн карт уншигч нь тэдний аппликэйшнд холбогдсон бөгөөд үйлчлүүлэгчид түүгээр хийсэн гүйлгээ бүртээ 0.2 хувийг хэмнэх боломж олгодог.

ОДОО ХУДАЛДАЖ АВ, ДАРАА НЬ ТӨЛ



Зээл олгох тухай ойлголт хоёр мянга гаруй жил оршин тогтнож ирсэн. Сүүлийн үед Шведийн финтек компани Klarna одоо худалдаж ав – дараа төл (BNPL) хэмээх орчин үеийн финтекийн шинэ хувилбарыг гаргаж ирсэн. Тус компани нь зээлийн таатай нөхцөлийг санал болгон хэрэглэгчдэд бараагаа хэсэгчлэн төлөх боломжийг олгодог бөгөөд дэлхий даяар 90 сая гаруй

үйлчлүүлэгч, 250,000 жижиглэн худалдаачдыг татаж чадсан. BNPL дэлхийн бусад олон оронд тренд болж байна. Ойрын хугацаанд BNPL шийдлүүд нь уламжлалт санхүүгийн системтэй холбогдсоноор, хэрэглэгчдэд онлайнар болон салбар дэлгүүрүүдээс хүүгүй худалдан авалт хийх боломжийг олгоно. Дебит эсвэл кредит картгүй ч гэсэн картын хүртээмж багатай зах зээлд чухал ач холбогдолтой.

Ковид-19 цар тахлын үеийн худалдан авагчийн зан үйлд үзүүлсэн нөлөө нь BNPL системийг түргэсгэх гол хөшүүрэг болж байгаа бөгөөд цаашид ч энэ хандлага үргэлжилсээр байна. Гэсэн хэдий ч BNPL нь хүссэн зүйлээ худалдаж авахад хялбар, төлбөрөө бүтэн төлөх шаардлагагүй нь хэрэглэгчдийн хувьд донтолт болж хувирдаг тул түүнийг тойрсон аюулууд байсаар байна. Жишээлбэл зээлдэгчдийн 43.0 хувь нь өнгөрсөн жил ядаж нэг удаа BNPL төлбөрөө алдсан байгаагаас үзвэл хэрэглэгчдийн дийлэнх нь энэ үйлчилгээний цаадах динамикийг ойлгохгүй өрөнд баригдаж байна.

КРИПТОВАЛЮТУУД



Өнөө үед дэлхийн бараг бүх оронд криптогийн тухай яригдаж байна. Криптовалют нь дэлхийн өнцөг булан бүрээс төлбөр төлөх, хүлээн авах боломжтой, гүйлгээний хураамж авдаггүй, олон улсын төлбөр тооцооны гүйлгээний шимтгэл багатай байдаг. Блокчейн ашиглан хийсэн гүйлгээг гуравдагч

этгээдийн зүгээс өөрчлөх боломжгүй гүйлгээний хувьд хулгайд алдах, хакер гэх мэт эрсдэлүүдээс найдвартай хамгаалдаг давуу талтай.

Төв банкууд өөрсдийн дижитал валютыг байршуулах үйл ажиллагааг хийж байна. Энэ нь криптовалютаар холбоотой тогтворгүй байдлыг багасгах зорилготой юм. Төв банкны дижитал валют нь хууль ёсны төлбөрийн хэрэгслийн статустай бөгөөд хувийн банкны хариуцлага биш тул хүмүүс банкны төлбөрийн чадварт найдах шаардлагагүй байршуулсан мөнгө хэзээд найдвартай байх болно.

Ойрын жилүүдэд бидний харах томоохон чиг хандлага бол нэгдсэн төлбөр тооцоог нэвтрүүлэх явдал юм. Одоо худалдаачид гуравдагч этгээдийн төлбөрийн шийдлүүдийг платформ дээрээ нэгтгэж байна. Худалдаачид төлбөр хүлээн авах үйлдлийг бүрэн автоматжуулснаар үйлчлүүлэгчдэдээ төлбөр тооцооны түргэн шуурхай, саадгүй үйлчилгээг санал болгохоос гадна цаг хугацаа, мөнгөө хэмнэх төдийгүй хувь хүмүүсийн гаргадаг санамсаргүй алдааг арилгах давуу талуудтай.

Финтекийн салбар төлбөрийн шинэлэг шийдлээр хувьсгал хийж байна. Хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдэд зориулсан төлбөрийн систем хурдацтай хөгжиж байна. Уламжлалт бэлэн мөнгө, картын төлбөр тооцооноос илүүтэй дэлхийн өнцөг булан бүрт байгаа хэрэглэгчдэд тав тухтай, хялбар байдлыг санал болгодог дижитал шийдлээр солигдож эхэлсэн. Хэдийгээр технологийн ихэнх нь эхэн үедээ явж байгаа ч санхүүгийн салбарын ирээдүйн талаар маш том хүлээлт үүсгэж байна.

Судлаачийн индэр

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн системийн хэмжээнд үзүүлэх эрсдэлийн нөлөөг эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалаар тооцон үнэлэхийг зорьсон. Системийн эрсдэлийг тодорхойлох үе шат, түүний шалгуур үзүүлэлт, макро болон микро түвшний үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй судалсан болно.

2010 оны 01 дүгээр улирлаас 2020 оны 4 дүгээр улирал хүртэлх 44 улирлын хугацааны цуваа тоон мэдээллийг 6 бүлгийн 50 үзүүлэлтээр тооцсон. Үүний тулд үзүүлэлт тус бүрийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож, түүнээс давсан нөхцөлд системийн эрсдэл, хямрал тохиолдоно гэсэн таамаглал дэвшүүлсэн. Системийн эрсдэл тохиолдох эсэх магадлалыг 2009 болон 2017 онд тохиолдсон санхүүгийн мөчлөгийн ёроол цэгийг жишиг болгосон ба хямрал тохиолдсон үеийн дараагийн улиралд ихэнх үзүүлэлт нь улаан болсон буюу хямралын нөлөөлөл ажиглагдсаар байв.

ОРШИЛ

Манай улсын хөрөнгийн зах зээлд 2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг шинээр баталснаар хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежмент, итгэмжлэн удирдах, үнэт цаасны давхар бүртгэл, хадгаламжийн сертификат, кастодиан банкны үйлчилгээ эрхлэх эрх зүйн орчин шинээр бүрдээд даруй 8 жил болжээ. Энэ хугацаанд зах зээлд шинээр хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Гүйцэтгэсэн:

*Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа
Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Будбаяр*

гарч, хувьцаа, бондоор санхүүжилт татах эрэлт нэмэгдэж хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа идэвхжих болов.

Хөрөнгийн зах зээл, тэдгээрийн оролцогч хоорондын холбоо хамаарал технологийн дэвшлийг даган улам нягт болж байгаа нь нэг талаас халдварлах нөлөөг ихэсгэж байна. 2009 оны санхүүгийн хямралаас өмнө хөрөнгийн зах зээлийн зохицуулагч нар системийн эрсдэлийг удирдахад төдийлөн анхаардаггүй байсан. Харин 2009 онд санхүүгийн хямрал нь хөрөнгийн зах зээлд үл хөдлөх хөрөнгийн хөөс хагарснаар зээлжих зэрэглэл, хейдж сан, тусгай зориулалтын компаниудаар дамжин нөлөөлсөн. Санхүүгийн хямралын нөлөөг үнэлэн дүгнэж Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)–аас системийн эрсдэлийг дараах хүчин зүйлс үүсгэснийг онцолсон.

1. Зарим банкны бус санхүүгийн байгууллагууд системийн эрсдэлийг үүсгэх, шилжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн;
2. Зах зээлд оролцогчид зохицуулалтын сул орон зай руу үйл ажиллагаагаа шилжүүлсэн;
3. Дэлхийн хөрөнгийн зах зээлийн холбоо хамаарал: Банк болон хөрөнгийн зах зээл хоорондын хамаарал системийн хэмжээнд нэмэгдсэн ба зохицуулагч байгууллагаас хянаагүй;
4. Бүтээгдэхүүний цогц байдал: Цогц байдал нь мэдээллийн тэгш бус байдлыг арилгах, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд хүндрэлтэй болгов. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид, gatekeeper нар цогц байдлын эрсдэлийн талаар ойлголт дутмаг байсан;
5. Бүтээгдэхүүний инновац: Шинэ бүтээгдэхүүн нь санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд

хүндрэлтэй болгож, мэдээллийн өртгийг нэмэгдүүлсэн. Эрсдэлийн талаарх дутмаг ойлголт нь эрсдэлийн мэдээллээр дутуу хангахад хүргэсэн;

- Зөрчилдөөний удирдлага: Санхүүгийн нэгдлийн ашиг сонирхлын зөрчлийг удирдахад илүү хүндрэлтэй болж, өртөг нэмэгдсэн;
- Биржийн бус зах зээлийн эрсдэлүүд: Биржийн бус зах зээлийн мэдээллийн хангалтгүй байдал, дэд бүтцийн хөгжил нь хямралын үеэр зах зээлд оролцогчдын итгэлийг бууруулсан.

Системийн эрсдэл нь зах зээлийн хэмжээ, төвлөрөл, халдварлах нөлөө, хамтын зан төлөв (сүргийн нөлөө, бөөний арилжаа, зах зээлийн царцаалт), холбоо хамаарал, хөшүүрэг болон мөчлөгөөс үүсдэг.

Санхүүгийн зохицуулагч байгууллагын чиг үүргийн нэг нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах байдаг. Үүний нэг хүчин зүйл нь системийн эрсдэлийг тодорхойлж, үнэлэн удирдах юм. Эрсдэлийг системийн хувьд ач холбогдолтой эсэхийг хөрөнгийн хэмжээ, холбоо хамаарал болон төвлөрөл /concentration/ гэсэн гурван шалгуураар үнэлдэг.

СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Системийн эрсдэлийг үнэлэх

Зураг. Системийн эрсдэлийг үнэлэх үе шат



Санхүүгийн хямрал үүсэхээс өмнө хөрөнгийн зах зээл дээрх системийн эрсдэлийг урьдчилан тодорхойлж, хянах шаардлагатай. Үүний тулд үнэт цаас гаргагч, санхүүгийн байгууллага бүтээгдэхүүн үйлчилгээ, хэлцэл, зах зээлийн хувьд эрсдэлийг тодорхойлно.

Системийг эрсдэлийг тодорхойлох

- Олон түвшний үзүүлэлтүүд – макро, микро, сэдэвчилсэн/ төвлөрсөн;
- Системийн эрсдэлийн хүчин зүйлс;

3. Хоёр талт хандлага – гадаад ба дотоод аюулгүй байдлыг хангахын тулд дээрээс доош, доороос дээш бүх эрсдэлт хүчин зүйлсийг харгалзан үздэг;

4. Дасан зохицох чадвар – систем дэх шалгуур үзүүлэлтүүдийг өөр өөр аргаар тодорхойлох;

5. Уян хатан байдал – өгөгдөл тоон мэдээлэл цуглуулах, шинэ эрсдэл гарах үед системийг хэрхэн хөгжүүлж болох гарцыг тодорхойлох.

Системийн эрсдэлийг тодорхойлогч макро түвшний үзүүлэлтүүд

Зураг. Системийн эрсдэлийг тодорхойлогч макро түвшний үзүүлэлтүүд

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	<ul style="list-style-type: none"> • Зээлийн хүүгийн хэлбэлзэл • Эдийн засгийн өсөлтийн хэмжээ • Мөнгөний нийлүүлэлт, зээлийн өсөлт • Дэлхийн зах зээлийн үнэлгээ/Орлогын хэмжээ • Инфляци • Санхүүгийн урсгал • Банк хоорондын зээл • Төв банкны хөрөнгө худалдан авах хөтөлбөр
Хөрөнгийн үнэ	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгийн үнэ (зээл, эзэмшигчдийн өмч, түүхий эд материал)
Төсвийн ерийн тогтвортой байдал	<ul style="list-style-type: none"> • Улсын ер • Зах зээлд оролцогчид, үнэт цаас гаргагчдын нийт ер эсвэл нийт хувь хүмүүсийн ерийн хэмжээ
Зах зээлийн тэнцвэргүй байдал	<ul style="list-style-type: none"> • Зах зээлийн олон жилийн дунджаас хазайсан байдал • Хөрөнгийн ангилалд гарсан томоохон өөрчлөлт • Хөшүүргийн түвшин
Санхүүгийн стресс	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн стресс индекс • Хөрөнгийн урт хугацааны үнийн зөрүү
Бусад	<ul style="list-style-type: none"> • Олон улсын хөрөнгийн урсгалын хөдөлгөөн • Геополитикийн орчин

Микро түвшний үзүүлэлтэд үнэт цаасны зах зээлээс үүсэх эрсдэл ордог бөгөөд микро түвшний үзүүлэлтийг зах зээлийн “өргөн хүрээ”–ний болон “сэдэвчилсэн” үнэт цаасны шалгуур үзүүлэлт гэж хуваан үздэг. Өргөн хүрээний үзүүлэлт болох аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, оролцогчид, үнэт цаасны зах зээлийн талаарх өргөн хүрээний мэдээллийг өгдөг ба системийн эрсдэлийг нэмэгдэж буйг макро түвшний үзүүлэлтээс илүү нарийвчлан тодорхойлж чаддаг.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай улсын хувьд хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд, зээлээр баталгаажсан үнэт цаас, хамтын хөрөнгө оруулалтын сан зэргүүд арилжаалагдаж байгаа ба хөрөнгийн зах зээлийн

бүтээгдэхүүний хувьд банк, даатгалын бүтээгдэхүүнтэй холбогдсон бүтээгдэхүүнгүй (зээлээр баталгаажсан үнэт цааснаас бусад) тул халдварлах эрсдэл бага байна.

Цаашид хөрөнгийн зах зээлийн эрсдэлийг тогтмол, нарийвчлал өндөртэйгөөр тооцох, мөн стресс тестийн аргачлалыг дэлгэрүүлэн судлах, тооцоололдоо ашиглах нь илүү үр дүнтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Agostino Capponi, W. Allen Cheng & Sriram Rajan. "Systemic Risk: The Dynamics under Central Clearing". 2015 https://www.financialresearch.gov/working-papers/files/OFRwp-2015-08_Systemic-Risk-The-Dynamics-under-Central-Clearing.pdf
- ASEAN. "Information on Transaction Flows and Settlement Infrastructures" [https://wpr4.adb.org/LotusQuickr/asean3abmf/Main.nsf/0/4B38375470B78E5748257CA800103914/\\$file/SF2%20Part2%20Korea%20\(KR\).pdf](https://wpr4.adb.org/LotusQuickr/asean3abmf/Main.nsf/0/4B38375470B78E5748257CA800103914/$file/SF2%20Part2%20Korea%20(KR).pdf)
- Bank of England. "Stress Testing". 2020 <https://www.bankofengland.co.uk/stress-testing>
- Carita Vitzthum. "Media Release". 2012
- <https://www.iosco.org/news/pdf/IOSCONEWS229.pdf>
- Duong, Phuong, Jinghui Liu & Ian Eddie. "Development of the regulatory framework of securities market supervision post-GFC". 2014
- El. Thalassinou & Th. Kiriazidis. "Degrees Of Integration In International Portfolio Diversification: Effective Systemic Risk". 2003
- https://www.ersj.eu/repec/ers/papers/03_12_p8.pdf
- IOSCO. "Mitigating Systemic Risk a Role for Securities Regulators". 2011 <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD347.pdf>
- IOSCO. "Risk Identification and Assessment Methodologies for Securities Regulators". 2014 <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD443.pdf>
- John Kambhu, Til Schuermann & Kevin J. Stiroh. "Hedge Funds, Financial Intermediation, and Systemic Risk". 2007
- <https://www.newyorkfed.org/medialibrary/media/research/epr/07v13n3/0712kamb.html>
- Kieran Dent & Ben Westwood. "Stress testing of Banks: an introduction". 2016 <https://www.bankofengland.co.uk/-/media/boe/files/quarterly-bulletin/2016/stress-testing-of-banks-an-introduction.pdf?la=en&hash=3C57129C772A42925EDABF0145129001AE7B245F>
- Po-Hsiang Huang, Shih-Cheng Lee & Szu-Lang Liao. "Illiquidity, Systemic Risk, and Macroprudential Regulation: The Case of Taiwan's Capital Market". 2014 http://www.sciencpress.com/Upload/JAFB%2fVol%204_3_4.pdf
- Rohini Tendulkar. "Cyber-crime, securities markets and systemic risk". 2013 <https://www.iosco.org/research/pdf/swp/Cyber-Crime-Securities-Markets-and-Systemic-Risk.pdf>
- Somnath Chatterjee & Andreas A Jobst. "Market-implied systemic risk and shadow capital adequacy". 2019
- <https://www.bankofengland.co.uk/-/media/boe/files/working-paper/2019/market-implied-systemic-risk-and-shadow-capital-adequacy.pdf>
- Tasca, Paolo and Battiston & Stefano. "Market Procyclicality and Systemic Risk". 2013 https://mpira.ub.uni-muenchen.de/45156/1/MPRA_paper_45156.pdf
- Toshiyuki Sakiyama and Tetsuya Yamada. "Market Liquidity and Systemic Risk in Government Bond Markets: A Network Analysis and Agent-Based Model Approach". 2016 <https://www.imes.boj.or.jp/research/papers/english/16-E-13.pdf>
- Werner Bijkerk, Rohini Tendulkar, Samad Uddin & Shane Worner. "Systemic Risk Identification in Securities Markets". 2012
- <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD461.pdf>

ХАВСРАЛТ

Мэдрэ эдийн засгийн нөхцөл байдал	1	2019												2020											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Бодит ДНБ-ний өсөлт (жилийн)		1.1	1.2	1.3	1.4	1.5	1.6	1.7	1.8	1.9	1.10	1.11	1.12	2.1	2.2	2.3	2.4	2.5	2.6	2.7	2.8	2.9	2.10	2.11	2.12
Инфляци (жилийн)		3.1	3.2	3.3	3.4	3.5	3.6	3.7	3.8	3.9	3.10	3.11	3.12	4.1	4.2	4.3	4.4	4.5	4.6	4.7	4.8	4.9	4.10	4.11	4.12
Төсвийн алдагдал/ДНБ		5.1	5.2	5.3	5.4	5.5	5.6	5.7	5.8	5.9	5.10	5.11	5.12	6.1	6.2	6.3	6.4	6.5	6.6	6.7	6.8	6.9	6.10	6.11	6.12
Улсын секторын нийт өр/ДНБ		7.1	7.2	7.3	7.4	7.5	7.6	7.7	7.8	7.9	7.10	7.11	7.12	8.1	8.2	8.3	8.4	8.5	8.6	8.7	8.8	8.9	8.10	8.11	8.12
Эзэмийн хүүгийн халбалзлал		9.1	9.2	9.3	9.4	9.5	9.6	9.7	9.8	9.9	9.10	9.11	9.12	10.1	10.2	10.3	10.4	10.5	10.6	10.7	10.8	10.9	10.10	10.11	10.12
Дэлхийн зах зээлийн үнэлгээний өөрчлөлт /тэрбум доллар/		11.1	11.2	11.3	11.4	11.5	11.6	11.7	11.8	11.9	11.10	11.11	11.12	12.1	12.2	12.3	12.4	12.5	12.6	12.7	12.8	12.9	12.10	12.11	12.12
Зах зээлийн үнэлгээний өөрчлөлтийн хуви		13.1	13.2	13.3	13.4	13.5	13.6	13.7	13.8	13.9	13.10	13.11	13.12	14.1	14.2	14.3	14.4	14.5	14.6	14.7	14.8	14.9	14.10	14.11	14.12
Эдийн засгийн өсөлтийн өөрчлөлт		15.1	15.2	15.3	15.4	15.5	15.6	15.7	15.8	15.9	15.10	15.11	15.12	16.1	16.2	16.3	16.4	16.5	16.6	16.7	16.8	16.9	16.10	16.11	16.12
Улсын нэгдсэн төсвийн тэнцлийн өөрчлөлт		17.1	17.2	17.3	17.4	17.5	17.6	17.7	17.8	17.9	17.10	17.11	17.12	18.1	18.2	18.3	18.4	18.5	18.6	18.7	18.8	18.9	18.10	18.11	18.12
Өрхийн орлогын өөрчлөлт (хот)		19.1	19.2	19.3	19.4	19.5	19.6	19.7	19.8	19.9	19.10	19.11	19.12	20.1	20.2	20.3	20.4	20.5	20.6	20.7	20.8	20.9	20.10	20.11	20.12
Өрхийн орлогын өөрчлөлт (хөдөө)		21.1	21.2	21.3	21.4	21.5	21.6	21.7	21.8	21.9	21.10	21.11	21.12	22.1	22.2	22.3	22.4	22.5	22.6	22.7	22.8	22.9	22.10	22.11	22.12
Мөнгөний нийтүлэлтийн өөрчлөлт		23.1	23.2	23.3	23.4	23.5	23.6	23.7	23.8	23.9	23.10	23.11	23.12	24.1	24.2	24.3	24.4	24.5	24.6	24.7	24.8	24.9	24.10	24.11	24.12
Улсын нийт зээлийн үлдэгдлийн өөрчлөлт		25.1	25.2	25.3	25.4	25.5	25.6	25.7	25.8	25.9	25.10	25.11	25.12	26.1	26.2	26.3	26.4	26.5	26.6	26.7	26.8	26.9	26.10	26.11	26.12
Банк хоорондын захар олгосон төгрөгийн зээлийн өөрчлөлт		27.1	27.2	27.3	27.4	27.5	27.6	27.7	27.8	27.9	27.10	27.11	27.12	28.1	28.2	28.3	28.4	28.5	28.6	28.7	28.8	28.9	28.10	28.11	28.12
ГШХО/ДНБ		29.1	29.2	29.3	29.4	29.5	29.6	29.7	29.8	29.9	29.10	29.11	29.12	30.1	30.2	30.3	30.4	30.5	30.6	30.7	30.8	30.9	30.10	30.11	30.12
Гадаад өр/ДНБ		31.1	31.2	31.3	31.4	31.5	31.6	31.7	31.8	31.9	31.10	31.11	31.12	32.1	32.2	32.3	32.4	32.5	32.6	32.7	32.8	32.9	32.10	32.11	32.12
Валютын нөөцийн өөрчлөлт		33.1	33.2	33.3	33.4	33.5	33.6	33.7	33.8	33.9	33.10	33.11	33.12	34.1	34.2	34.3	34.4	34.5	34.6	34.7	34.8	34.9	34.10	34.11	34.12
Валютын нөөц - импортын хэрэгцээг хангах түвшин		35.1	35.2	35.3	35.4	35.5	35.6	35.7	35.8	35.9	35.10	35.11	35.12	36.1	36.2	36.3	36.4	36.5	36.6	36.7	36.8	36.9	36.10	36.11	36.12
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн өөрчлөлт		37.1	37.2	37.3	37.4	37.5	37.6	37.7	37.8	37.9	37.10	37.11	37.12	38.1	38.2	38.3	38.4	38.5	38.6	38.7	38.8	38.9	38.10	38.11	38.12
Бодит үйлчилж буй ханшийн өөрчлөлт		39.1	39.2	39.3	39.4	39.5	39.6	39.7	39.8	39.9	39.10	39.11	39.12	40.1	40.2	40.3	40.4	40.5	40.6	40.7	40.8	40.9	40.10	40.11	40.12
Экспортын өсөлт		41.1	41.2	41.3	41.4	41.5	41.6	41.7	41.8	41.9	41.10	41.11	41.12	42.1	42.2	42.3	42.4	42.5	42.6	42.7	42.8	42.9	42.10	42.11	42.12
Нүүрсний үнийн өөрчлөлт		43.1	43.2	43.3	43.4	43.5	43.6	43.7	43.8	43.9	43.10	43.11	43.12	44.1	44.2	44.3	44.4	44.5	44.6	44.7	44.8	44.9	44.10	44.11	44.12
Алтын үнийн өөрчлөлт		45.1	45.2	45.3	45.4	45.5	45.6	45.7	45.8	45.9	45.10	45.11	45.12	46.1	46.2	46.3	46.4	46.5	46.6	46.7	46.8	46.9	46.10	46.11	46.12
M1 мөнгөний өсөлт		47.1	47.2	47.3	47.4	47.5	47.6	47.7	47.8	47.9	47.10	47.11	47.12	48.1	48.2	48.3	48.4	48.5	48.6	48.7	48.8	48.9	48.10	48.11	48.12
M2 мөнгөний өсөлт		49.1	49.2	49.3	49.4	49.5	49.6	49.7	49.8	49.9	49.10	49.11	49.12	50.1	50.2	50.3	50.4	50.5	50.6	50.7	50.8	50.9	50.10	50.11	50.12
Дотоодын зээлийн өсөлт		51.1	51.2	51.3	51.4	51.5	51.6	51.7	51.8	51.9	51.10	51.11	51.12	52.1	52.2	52.3	52.4	52.5	52.6	52.7	52.8	52.9	52.10	52.11	52.12
Дотоодын зээл/ДНБ		53.1	53.2	53.3	53.4	53.5	53.6	53.7	53.8	53.9	53.10	53.11	53.12	54.1	54.2	54.3	54.4	54.5	54.6	54.7	54.8	54.9	54.10	54.11	54.12
Хувийн сектор олгосон зээл/ДНБ		55.1	55.2	55.3	55.4	55.5	55.6	55.7	55.8	55.9	55.10	55.11	55.12	56.1	56.2	56.3	56.4	56.5	56.6	56.7	56.8	56.9	56.10	56.11	56.12
Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл/ДНБ		57.1	57.2	57.3	57.4	57.5	57.6	57.7	57.8	57.9	57.10	57.11	57.12	58.1	58.2	58.3	58.4	58.5	58.6	58.7	58.8	58.9	58.10	58.11	58.12
Гадаад валют болон төгрөгийн хүүгийн зөрүүний өөрчлөлт		59.1	59.2	59.3	59.4	59.5	59.6	59.7	59.8	59.9	59.10	59.11	59.12	60.1	60.2	60.3	60.4	60.5	60.6	60.7	60.8	60.9	60.10	60.11	60.12
Банк хоорондын захын хүү		61.1	61.2	61.3	61.4	61.5	61.6	61.7	61.8	61.9	61.10	61.11	61.12	62.1	62.2	62.3	62.4	62.5	62.6	62.7	62.8	62.9	62.10	62.11	62.12
Зээл халгалмажийн хүүгийн зөрүү		63.1	63.2	63.3	63.4	63.5	63.6	63.7	63.8	63.9	63.10	63.11	63.12	64.1	64.2	64.3	64.4	64.5	64.6	64.7	64.8	64.9	64.10	64.11	64.12
Банкны нийт зээл, халгалмажийн харьцаа		65.1	65.2	65.3	65.4	65.5	65.6	65.7	65.8	65.9	65.10	65.11	65.12	66.1	66.2	66.3	66.4	66.5	66.6	66.7	66.8	66.9	66.10	66.11	66.12
Нэг жилээс бага хугацаатай ОУ-ын зээлзэгийн хэмжээ болон өөрчлөлт		67.1	67.2	67.3	67.4	67.5	67.6	67.7	67.8	67.9	67.10	67.11	67.12	68.1	68.2	68.3	68.4	68.5	68.6	68.7	68.8	68.9	68.10	68.11	68.12
Долларжилт		69.1	69.2	69.3	69.4	69.5	69.6	69.7	69.8	69.9	69.10	69.11	69.12	70.1	70.2	70.3	70.4	70.5	70.6	70.7	70.8	70.9	70.10	70.11	70.12
Төв банкнаас банкны системд олгосон зээл, санхүүжилтийн өсөлт		71.1	71.2	71.3	71.4	71.5	71.6	71.7	71.8	71.9	71.10	71.11	71.12	72.1	72.2	72.3	72.4	72.5	72.6	72.7	72.8	72.9	72.10	72.11	72.12
Банкны активын өгөөж (ROA)		73.1	73.2	73.3	73.4	73.5	73.6	73.7	73.8	73.9	73.10	73.11	73.12	74.1	74.2	74.3	74.4	74.5	74.6	74.7	74.8	74.9	74.10	74.11	74.12
Чанаргүй зээл/Нийт зээл (NPL ratio)		75.1	75.2	75.3	75.4	75.5	75.6	75.7	75.8	75.9	75.10	75.11	75.12	76.1	76.2	76.3	76.4	76.5	76.6	76.7	76.8	76.9	76.10	76.11	76.12
Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө		77.1	77.2	77.3	77.4	77.5	77.6	77.7	77.8	77.9	77.10	77.11	77.12	78.1	78.2	78.3	78.4	78.5	78.6	78.7	78.8	78.9	78.10	78.11	78.12
Үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээл / нийт зээлийн харьцаа (Ипотезийн зээл)		79.1	79.2	79.3	79.4	79.5	79.6	79.7	79.8	79.9	79.10	79.11	79.12	80.1	80.2	80.3	80.4	80.5	80.6	80.7	80.8	80.9	80.10	80.11	80.12
Зарилгын салбарт олгосон зээл/нийт зээлийн харьцаа		81.1	81.2	81.3	81.4	81.5	81.6	81.7	81.8	81.9	81.10	81.11	81.12	82.1	82.2	82.3	82.4	82.5	82.6	82.7	82.8	82.9	82.10	82.11	82.12
ТОП-20 индексийн өөрчлөлт		83.1	83.2	83.3	83.4	83.5	83.6	83.7	83.8	83.9	83.10	83.11	83.12	84.1	84.2	84.3	84.4	84.5	84.6	84.7	84.8	84.9	84.10	84.11	84.12
Уул уурхайн компанийн хувьцааны ханшийн өөрчлөлт (Тавантолгой)		85.1	85.2	85.3	85.4	85.5	85.6	85.7	85.8	85.9	85.10	85.11	85.12	86.1	86.2	86.3	86.4	86.5	86.6	86.7	86.8	86.9	86.10	86.11	86.12
Уул уурхайн компанийн хувьцааны ханшийн өөрчлөлт (Оюу толгой)		87.1	87.2	87.3	87.4	87.5	87.6	87.7	87.8	87.9	87.10	87.11	87.12	88.1	88.2	88.3	88.4	88.5	88.6	88.7	88.8	88.9	88.10	88.11	88.12
Уул уурхайн компанийн хувьцааны ханшийн өөрчлөлт (Mongolian Mining Corporation)		89.1	89.2	89.3	89.4	89.5	89.6	89.7	89.8	89.9	89.10	89.11	89.12	90.1	90.2	90.3	90.4	90.5	90.6	90.7	90.8	90.9	90.10	90.11	90.12
Засгийн газрын бондын арилжааны өөрчлөлт		91.1	91.2	91.3	91.4	91.5	91.6	91.7	91.8	91.9	91.10	91.11	91.12	92.1	92.2	92.3	92.4	92.5	92.6	92.7	92.8	92.9	92.10	92.11	92.12
Хотын хэрэглээний үнийн индекс		93.1	93.2	93.3	93.4	93.5	93.6	93.7	93.8	93.9															

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛД СУРАЛЦЬЯ (ХИЧЭЭЛ №2)

Санхүүгийн хэрэгслийн үнэлгээг тооцоход өнөөгийн ба ирээдүйн үнэ цэнийг тооцоолох зайлшгүй шаардлагатай. Ямар нэг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад хэдий хугацаанд хэдийг олох буюу өгөөж нь хэд байх, хэдий хугацаанд ямар хэмжээний хүүтэй зээлбэл, эсвэл хөрөнгө оруулбал тухайн хугацааны дараа таны тооцоолсон дүнд хүрэх зэрэг хөрөнгө оруулалтаа цаг хугацаатай уялдуулсан тооцооллыг хөрөнгө оруулагч хийнэ.

Санхүү, хөрөнгийн зах зээлийн харилцаа өндөр хөгжсөн газарт “мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ” буюу “time value of money” гэсэн суурь ойлголт дээр мөнгөний урсгал хөдөлгөөнийг тооцоолдог. Орчин цагийн монгол хэлэнд “мөнгө унтдаггүй” гэх хэлц үгээр маш энгийнээр тодорхой илэрхийлсэн байдаг. Энэ нь мөнгө хором бүрт өгөөж өгдөг, тодорхой хугацааны дараах мөнгөний хэмжээ одоогийнхоос ямагт их байна гэсэн санхүүгийн суурь ойлголт юм.

Энэ тэнцвэрээс ₮102.68–ийн 10.0 хувийн хүүтэй 98 хоногийн өмнөх одоогийн үнэ цэнийг тооцвол:

$$\frac{102.68}{(1+0.10 \times \frac{98}{365})} = \text{₮}100 = \text{₮}100$$

Хөрөнгө оруулалтын хүү, хугацаа мэдэгдэж байвал бид өнөөгийн болон ирээдүйн үнэ цэнийг тооцоолж болно. Тэгвэл, өнөөдөр хэдийг (өнөөгийн үнэ цэнэ) хөрөнгө оруулахад хэд болгон өсгөхөө (ирээдүйн үнэ цэнэ) төсөөлөөд эндээс хүү нь хэд байхыг тооцоолж болно: Үүний тулд дээрх тэнцвэрээс хүүг олбол:

$$\text{Хүү} = \left(\frac{\text{өнөөгийн үнэ}}{\text{ирээдүйн үнэ}} - 1 \right) \times \frac{\text{жил}}{\text{хоног}}$$

Богино хугацааны хөрөнгө оруулалт

Ирээдүй ба одоогийн үнэ

Та ₮100 нэг жилийн хугацаанд 10.0 хувийн хүүтэй банкинд хадгалсан гэж бодъё, тэгвэл та жилийн дараа:

$$\text{₮}100 \times (1 + 0.10) = \text{₮}110$$

Энэ тохиолдолд ₮110 нь өнөөдрийн ₮100 –ийн ирээдүйн үнэ цэнэ юм, харин ₮100 нь ирээдүйн нэг жилийн дараах ₮110 –ийн одоогийн үнэ цэнэ юм.

Үүнтэй адил ₮100 –ийн жилийн 10.0 хувийн хүүтэй 98 хоногийн дараах ирээдүйн үнэ цэнийг доорх байдлаар тооцоолно:

$$\text{₮}100 \times (1 + 0.10 \times \frac{98}{365}) = 102.68$$

Урт хугацааны хөрөнгө оруулалт

Богино хугацааны хөрөнгө оруулалтын ирээдүйн үнэ цэнэ тооцох дээрх тооцооллыг энгийн хүүгийн нөхцөлөөр бодсон. Хэрэв хөрөнгө оруулалтын хугацаа нэг жилээс их, нийлмэл хүүтэй нөхцөлд тооцооллыг нийлмэл хүүгийн аргаар бодно. 3 жилийн хугацаатай, 10.0 хувийн хүүтэй ₮100 –ийн ирээдүйн үнэ цэнийг дараах байдлаар тооцоолно:

$$\text{₮}100 \times (1+0.10)^3 = \text{₮}133.10$$



САНХҮҮГИЙН ЭРСДЭЛЭЭС ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

Санхүүгийн эрсдэл гэдэг нь: хөрөнгө оруулж, хуримтлуулсан хөрөнгөө алдах болон алдаж болохуйц нөхцөл байдалд орохыг хэлнэ.

Эрсдэл үүсгэж болох хүчин зүйлс:



Мэдээллийн хомс байдал

- Хангалттай мэдээлэл авсан эсэхээ нягтлах
- Харилцагч байгууллагаасаа нэмэлт мэдээлэл шаардах
- Харилцагч байгууллагын талаар судлах



Хүлээгдээгүй үр дүн

- Эрсдэл, өгөөжөө тооцож, түүний алдах магадлалыг таамаглах
- Эдийн засгийн хүчин зүйлсийг тооцох



Хэрэгцээндээ тохироогүй бүтээгдэхүүн сонгох

- Санхүүгийн зорилго, хэрэглээгээ нарийвчлан тодорхойлох



Залилан болон хулгайд өртөх

- Нууц үгээ тогтмол шинэчлэх
- Даатгуулах

“Эрх ашгаа хамгаалах”

талаар нэмэлт мэдээллийг дараах эх сурвалжаас унших боломжтой



Санхүүгийн эрсдэлээс хамгаалах гол арга нь
**Та өөрийнхөө эрх ашгаа хамгаалахад
анхаарах** юм шүү...



<http://www.frc.mn/a/3752>



<https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/31.pdf>



<http://www.frc.mn/resource/frc/File/2021/03/24/Inba5zy3icimsqa/garin%20avlaqa.pdf>





САНХҮҮГИЙН ХОХИРОГЧ БОЛСОН НӨХЦӨЛД ХААНА ХАНДАХ ВЭ?

1 Зохицуулалттай этгээд болон санхүүгийн үйлчлүүлэгч хооронд үүссэн маргаантай холбоотой асуудлаар доорх хуулийн хүрээнд **Санхүүгийн зохицуулах хороонд** өргөдөл гаргах /нөхөн төлбөр олгохгүй байх, үнэт цаас зөвшөөрөлгүй арилжих, зээлийн гэрээ гэх мэт/



Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль

Даатгалын тухай хууль

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль

Жолоочийн даатгалын тухай хууль

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль

Өргөдөл гаргах хэлбэр



Бичгээр



Утсаар /51-261275/



Цахимаар

[/http://www.frc.mn/i/Feedback/](http://www.frc.mn/i/Feedback/)

Мөн **оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа шүүхэд** өргөдөл гарган, зохицуулалттай этгээд болон санхүүгийн үйлчлүүлэгч хооронд үүссэн **гэрээний маргааныг** шийдвэрлүүлж болно.

2 Санхүүгийн асуудалтай холбоотой эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөлд өргөдлийг **харьяа аймаг, дүүргийн цагдаагийн газарт** гаргах



Бичгээр



И-мэйлээр

[/complaints@police.gov.mn/](mailto:complaints@police.gov.mn/)



Утсаар /102/

Гэмт хэргийн шинж чанараас хамааран **Эрүүгийн цагдаагийн алба, Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар** өргөдлийг шийдвэрлэдэг.

3 Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч монопол давуу байдлаа урвуугаар ашигласан тохиолдолд **Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт** хандах



Бичгээр



И-мэйлээр

[/contact@afccp.gov.mn/](mailto:contact@afccp.gov.mn/)



Утсаар /115/

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2022 ОНД ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЛААР ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ 10 АРГА ХЭМЖЭЭ

Дэлхийн 43 улсад төвтэй нийт 301 компанийн захирлуудын дунд хийсэн судалгаагаар оролцогчдын дөрөвний гурав нь компанийн урт хугацааны стратегийн амжилтад уур амьсгалын нөлөөлөл маш чухал гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэсэн хэдий ч нийт судалгаанд оролцогчдын зөвхөн 72.0 хувь нь өөрийн компанийн хэрэгжүүлэх уур амьсгалын зорилгодоо хүрнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн, харин 43.0 хувь нь нүүрстөрөгчийн хийг хэрхэн бууруулах зорилгоо тодорхойлоогүй байна. Иймд энэ ойлголтын зөрүүг арилгахад компанийн ТУЗ дараах асуудлуудад анхаарлаа хандуулах шаардлага нэгэнт болжээ.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР ТУЗ-ИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛД ҮНЭЛЭЛТ ӨГӨХ

Танай компанийн ТУЗ юуг мэддэг, юу мэддэгийг үнэлэх. Судалгаагаар ТУЗ-ийн 85.0 хувь нь уур амьсгалын талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарчээ. Захирлууд санхүүгийн болон ажлын гүйцэтгэл, шинэ хөрөнгө оруулалт зэрэг байнга хэлэлцдэг асуудлын талаар хэнээс ч илүүг мэддэг. Гэвч эдгээр асуудлуудад уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлөх талаар хангалттай мэддэг үү?



ТУЗ-ИЙН ҮР ДҮН, МЭДЛЭГИЙГ ХЭРХЭН НЭМЭГДҮҮЛЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ

ТУЗ-д салбар болгоны талаар мэргэшсэн хүн байх боломжгүй боловч уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтэн хэрэгтэй юу? Үүнд цаг уурын хөндлөнгийн зөвлөх хэрэгтэй, эсхүл сургалтын хөтөлбөр хэрэгтэй юу?



ТУЗ-Д ШИНЭЧЛЭЛ ХИЙХ

Хэдийгээр ТУЗ-д шинээр гишүүн элсүүлэхгүй эсвэл шинэ ур чадварыг хөгжүүлэхгүйгээр тогтсон ч цаг уурын

мэргэжилтнийг ажиглагч эсвэл зөвлөхөөр ажиллуулах шаардлагатай.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХӨТӨЛБӨРТӨӨ ТУСГАХ

Заримдаа энэ нь бие даан хэлэлцэх асуудал болж болно. Учир нь уур амьсгалын өөрчлөлтийг бүх зүйлстэй холбох нь хэтрүүлсэн мэт санагдаж байвал бодитоор хэрэгжүүлэхийн тулд бизнесийн нэгж, бүтээгдэхүүн, эсвэл хөрөнгөтэй холбон томруулж үзэх нь чухал.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦТЭЙ УЯЛДУУЛАХ

Тухайн салбар эсвэл ТУЗ-ийн мэдлэгийн түвшнээс хамаарч өөр өөр арга барилыг ашиглаж болох ба хэрэв ТУЗ-ийн дэргэд тогтвортой байдлын хороотой бол компанийн бизнест уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийн талаар ярилцах боломж байна. Судалгаанд оролцогчдын дөрөвний нэг нь дээрх хорооны гишүүд байсан бол бусад бүтэц нь мөн хамааралтай байж болно: жишээлбэл, мэргэжилтэн, ТУЗ-ийн хараат бус гишүүн, эсвэл холбогдох ажлын хэсэг гэх мэт.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР ТОДОРХОЙ ЗОРИЛТ ДЭВШҮҮЛЭХИЙГ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГТ ҮҮРЭГ БОЛГОХ

Судалгаанд хамрагдсан компаниудын 84.0 хувь нь гүйцэтгэх захирлууд илүү сайн ажиллах боломжтой гэв.



УДИРДАХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ УУР АМЬСГАЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГТЭЙ УЯЛДУУЛАН, ТЭДГЭЭРИЙН УРАМШУУЛЛЫГ УУР АМЬСГАЛЫН ЗОРИЛТТОЙ УЯЛДУУЛАХ

Уур амьсгалын өөрчлөлтийн зорилтуудыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд компанийн удирдах ажилтны хариуцлагыг тодорхойлж, ажилд авах, урамшуулал олгох шийдвэрийг түүнтэй уялдуулах шаардлагатай. Судалгаанд оролцогчдын дөнгөж 35.0 хувь нь уур амьсгалын өөрчлөлтийг компанийн шинэ гүйцэтгэх захирлыг сонгохтой уялдуулсан бол зөвхөн 26.0 хувь нь уур амьсгалын өөрчлөлтийг гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн хэмжүүрт оруулсан байв.



УУР АМЬСГАЛЫН ТАЙЛАНГ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ШИГ БОЛГОХ

Нийтээр дагаж мөрдөх тайлагнах стандарт байхгүй нь өнгөрсөн хугацаанд тайлан гарахгүй байх шалтаг болсон хэдий ч 2024 он гэхэд дэлхий даяар уур амьсгалын тайланг стандартчилах болно. Үүнд компанийн аудиторуд зааварчилгаа өгөх шаардлагатай бөгөөд эсрэг тохиолдолд чадамжтай этгээдээр солих талаар бодох цаг нь болсон.



КОМПАНИЙНХАА ЗОРИЛГЫГ ТОДРУУЛАХ

Уур амьсгалын өөрчлөлтийг бодитоор харахын тулд нарийвчилсан мэдээллийг томруулж, том зургаар нь харахыг зөвлөж байна. Ингэснээр таны хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээ амжилтад хүрэх магадлал өндөр байх болно.




ЭЦЭСТ НЬ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ УДИРДАХ

ТУЗ-ийн гишүүд уур амьсгалын өөрчлөлтийн зорилгыг нэн тэргүүнд тавьж, үүнийгээ нээлттэйгээр хэлэлцүүлснээр ТУЗ болон компани энэ онд болон цаашид илүү сайн ажиллаж, үр дүнд хүрч чадах талаар эргэцүүлэх нь чухал.

ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) үүрэг хариуцлагынхаа цар хүрээ, нарийн төвөгтэй байдалд хэт автсанаар юуг, хаанаас эхлүүлэхээ мэдэхгүй байх боломжтой ч дээр өгүүлсэн 10 ажлыг хэрэгжүүлснээр уур амьсгалын өөрчлөлтийг удирдах замын ерөнхий зураг тодорхой болно гэдэгт итгэлтэй байна.

Эх сурвалж: Harvard Business Review



ХЭРЭГЛЭГЧ

2021 ОНЫ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТАЙЛАН

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, санал, дүгнэлт гарган хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. 2021 онд цаасаар болон цахимаар нийт 699 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр буюу цаасаар нийт 475 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч тайлант хугацаанд 454 өргөдлийг шийдвэрлэж, 21 өргөдөл хуулийн хугацаанд хянаж байна.

Цахимаар ирүүлсэн 224 өргөдөл гомдолд хариу өгч, утсаар болон ажлын байран дээр ирсэн 2206 иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Хүснэгт. Нийт өргөдлийн тоо (цаасаар)

№	Салбар	2021/I	2021/II	2021/III	2021/IV	2021 он Нийт
1	Даатгал	59	33	47	62	201
2	Үнэт цаас	21	28	33	61	143
3	ББСБ	15	18	13	38	84
4	ХЗХ	2	3	2	14	21
5	Бусад	11	4	–	11	26
	Нийт	108	86	95	186	475

Хүснэгт. Нийт өргөдлийн тоо (цахимаар)

№	Салбар	2021/I	2021/II	2021/III	2021/IV	2021 он Нийт
1	Даатгал	4	2	3	10	19
2	Үнэт цаас	5	23	2	7	37
3	ББСБ	13	7	5	5	30
4	ХЗХ	2	–	–	–	2
5	Бусад	6	7	95	28	136
	Нийт	30	39	105	50	224

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИЖ БҮРЭН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ.

Дэлхийн чөлөөт худалдааны хамгийн том хэлэлцээр болох Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр /RCEP/ 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэллээ.

Тус хэлэлцээр хэрэгжиж эхэлснээр гишүүдийн харилцан нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний нэр төрлүүдийн 90 гаруй хувьд ногдох татвар буурах юм. Мөн гарын үсэг зурсан талуудын хооронд худалдааны оновчтой, хялбаршуулсан дүрэм журмыг мөрдөж, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын салбар илүү өргөн хүрээнд нээлттэй болсноор бодит үр ашгийг авчирна.

“APPLE” КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 3 ИХ НАЯД АМ.ДОЛЛАР ДАВСАН АНУ-ЫН АНХНЫ КОМПАНИ БОЛЛОО.



01 дүгээр сарын 3-ны өдөр “Apple” компанийн зах зээлийн үнэлгээ нь 3 их наяд ам.долларт хүрсэн АНУ-ын анхны компани болжээ. Үүнд Ковид-19-ийн цар тахлын улмаас зайнаас сурах, ажиллах шаардлага нэмэгдсэнээр “iPhone” гар утас, зөөврийн компьютеруудын борлуулалт өссөн нь ихээхэн нөлөөлсөн байна. Тэрээр 2018 оны 8 дугаар сард 1 их наяд ам.доллар, 2020 оны 8 дугаар сард 2 их наяд ам.долларын босгыг давсан билээ.

Мэдээллийн технологийн салбарт тэргүүлэгч “Apple” компанийн зах зээлийн үнэлгээ нь Японы хамгийн том компаниудын нэгд тооцогддог “Toyota Motor” компанийнхаас ойролцоогоор 10 дахин их байгаагаас гадна Токиогийн хөрөнгийн биржийн эхэн хэсэгт бүртгэлтэй бүх компанийн хөрөнгийг нийлүүлсний тэн хагастай тэнцэж байна.

АНУ-д зах зээлийн үнэлгээгээрээ тэргүүлэгч гурван компани нь бүгд технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд “Apple”-ийн араас “Microsoft” хоёрдугаар байрт бичигдэж байгаа бол “Google” компанийн эцэг “Alphabet” компани гуравдугаарт жагсаж байна.

ИХ БРИТАНИД ГОЛ САЛБАНУУДЫГ ГАДНЫН НӨЛӨӨНӨӨС ХАМГААЛАХ ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЖЭЭ.



Их Британийн гол салбаруудыг гаднын нөлөөнөөс хамгаалах зорилготой Үндэсний аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын тухай хууль тус улсад 01 дүгээр сарын 4-ний өдрөөс хэрэгжиж эхэлжээ.

Шинэ хуулийн төслийг 2018 оноос эхлэн боловсруулсан бөгөөд тус хуулийн зорилгуудын нэг нь Их Британид чухал ач холбогдолтой аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийг гадаадын хяналтад орохоос урьдчилан сэргийлэх юм.

Шинэ журамд хамаарах эдийн засгийн гол 17 салбарын дунд эрчим хүч, иргэний зориулалттай цөмийн төслүүд, батлан хамгаалах, давхар зориулалттай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэр, сансар, хиймэл дагуулын технологи, хиймэл оюун ухаан, квант технологи, дэвшилтэт робот, синтетик биологи зэрэг салбар багтсан байна.

НЕФТИЙН ҮНЭ ӨСЖЭЭ.

Нефть олборлогч томоохон орнууд 2 дугаар сард олборлолтоо аажмаар нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцсоны дараа нефтийн үнэ 01 дүгээр сарын 04-ний өдөр өсжээ.

Тодруулбал, Нью-Йоркийн биржид “WTI” маркийн нэг торх нефтийн 2 дугаар сард нийлүүлэх фьючерс хэлцлийн үнэ 91 цент буюу 1.2 хувиар өсөж, 76.99 ам.долларт хүрсэн байна.

Мөн Лондоны “ICE” биржид “Brent” маркийн нефтийн 3 дугаар сард нийлүүлэх үнэ 1.02 ам.доллар буюу 1.3 хувиар өсөж, 80 ам.долларт хүрчээ.

Нефть олборлогч орнуудын байгууллага болон түүний холбоотнууд /ОПЕК+/ 01 дүгээр сарын 04-ний өдөр цахимаар хуралдаж, 2 дугаар сард өдөрт олборлох нефтийн хэмжээгээ 400 мянган торхоор нэмэгдүүлэхээр тохиролцсон байна.

ХЯТАДЫН ДНБ 2022 ОНД 5.6 ХУВИАР ӨСНӨ ГЭЖ ТААМАГЛАЖЭЭ.



БНХАУ-ын ДНБ 2022 онд 5.6 хувиар өснө гэж The Hongkong and Shanghai Banking Corporation Limited /HSBC/ банк таамагласан байна.

"HSBC" банкны Ази-номхон далай, Хятадын эдийн засгийг хариуцсан судалгааны газрын ахлах эдийн засагч Чүй Хунбин нь БНХАУ 2022 онд эдийн засгийг нэгдүгээрт тавьж, тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогыг үндсэн чиглэлээ болгож байгаа гэдгийг хэлсэн байна.

Түүний таамаглаж буйгаар, энэ онд суурь инфляцын түвшин бага байгаа нь мөнгө, төсвийн бодлогод хангалттай орон зайг бий болгож, бодлогын дэмжлэг нь эдийн засгийн өсөлтийн шинэ хөдөлгөгч хүч болох дунд, том хэмжээний үйлдвэрлэл, ногоон хөрөнгө оруулалт, технологийн хөгжлийг дэмжих төлөвтэй байна.



ДЭЛХИЙН ТОМООХОН КОМПАНИУДЫН УДИРДЛАГУУД 2022 ОНД ЭДИЙН ЗАСАГ САЙЖИРНА ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА.

Дэлхийн томоохон компаниудын удирдлагуудын 77.0 хувь нь 2022 онд дэлхийн эдийн засгийн төлөв байдал сайжирна гэж таамаглажээ. Энэ нь сүүлийн 10 жилийн хамгийн өөдрөг таамаг юм гэж “PwC” зөвлөх компанийн явуулсан судалгаанд дурдсан байна.

Хамгийн өөдрөг таамгийг Энэтхэг Улс дэвшүүлсэн бөгөөд тус санал асуулгад оролцсон компаниудын удирдлагуудын 94.0 хувь нь мөн Итали 89.0 хувь, Франц 85.0 хувь, Япон 83.0 хувь болон Их Британийн компаниудын удирдах албан тушаалтнууд 82.0 хувийн эерэг динамик ажиглагдана гэж үзсэн байна.

Зарим орны өөдрөг таамаг өнгөрсөн оны судалгаатай харьцуулахад буурчээ. Дэлхийн томоохон компаниудын удирдлагуудын 43.0 хувь нь эдийн засаг сэргэхэд инфляц болон ДНБ-ий хэлбэлзэл нөлөөлж болзошгүй гэж санаа зовж байгаа аж.

Казахстан Улсад үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор ураны үнэ өсжээ.

Казахстанд болж буй үйл явдалтай холбоотойгоор дэлхийн худалдааны зах зээлийн ураны үнэ 8.0 орчим хувиар өссөн байна. Дэлхийн ураны үнийг хянадаг “UxC” тусгай платформын мэдээллийг “Bloomberg” агентлаг олон нийтэд танилцуулжээ.


Казахстан Улс дэлхийн ураны нийлүүлэлтийн 40.0 орчим хувийг үйлдвэрлэдэг байна. Эсэргүүцлийн жагсаал өрнөсөнтэй холбоотойгоор байгалийн уран олборлодог Казахстаны “Казатомпром” компанийн хувьцаа Лондоны хөрөнгийн бирж дээр 8.8 хувиар унажээ.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,356.45 -53.68 (-1.22%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


27,017.68 -100.62 (-0.37%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,543.00 +74.31 (+1.02%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,539.29 -315.83 (-2.28%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

